

## ГАНГА МӨРӨН

Б.Нямаа /Төр Засгийн Амралт  
Үйлчилгээний Цогцолборын дарга/

Дорно зүгийг сахигч “Дридрааидраа” бурхан  
Ивээхийн цагт  
Домог шашидирын эзэн тэнгэр язгуурт “Гришинаа”  
Илбэн адислаж  
Газар лусыг баярлуулж  
Гамшиг бузраас хүн төрөлхтнийг ариусгаараа гэж  
Ганга мөрнийг олны төлөө  
Урсгалаа гэнэ.  
Индраа их тэнгэр  
Ивээж хайрлахын үед  
Их хар уст “Брахма” нуур  
Ивэлэн садарч  
“Будлан” их уулсын сэрүүн царамнаас  
Будан хүдэн нэвтлэн  
Бургилан оргилон Ганга мөрөн  
Буулаа гэнэ.  
Тэнгэр “Вишнүү”-гийн гоо охидын  
Энхэр тансаг аялгуугаар хөглөж  
Согтуу юм шиг дэнхэлзэх  
Сүрлэг цэнхэр уулсын өлмийг илүүлж  
Галбирваасан их шугуйн дундуур  
Ганга мөрнийг урсгалаа гэнэ.  
Замбуу тивийн өнгийг гоёж  
Замбага цэцгийн өнгө үнэрийг  
Нэмлээ гэнэ.  
Цалин цагаан мөнгөн агуй сүвлэн урсгаж  
Цаглашгүй ариун дагийн  
Болголоо гэнэ.  
Наран саран хоёр наадаж тоглохын үед  
Намэсаа их ертөнц налайж дэлгэрэхийн цагт  
Буман хот тосгодоор эрэг хөвөөгий нь чимэж  
Бурхан бумбын орон үзэсгэлэнт Жагар нутгийн  
Дэлгэр талын дундуур  
Дөлгөөхөн урсгалаа гэнэ.  
Тэнгэрийн рашаан Ганга мөрөн  
Алтан нарыг алгаараа өргөж  
Хэдэн зуунд мандаасныг,  
Газрын охь Ганга мөрөн

Алиман сарыг усандаа өлгийдөж  
 Хэдэн жил жаргаасныг  
 Хэнч мэдэхгүй ч  
 Холын Ганга мөрний талаар  
 Хэрсүү монгол өвгөдийн  
 Хэлэлцэж байхыг сонссон.  
 Арьяабал, ариун Ганга мөрөн минь  
 Аварч өршөө  
 Цастын орон тэнгэр уул минь  
 Цаг үргэлж өршөө гэж залбирч байхыг  
 Үзсэн би  
 Амьд явсан цагтаа Ганга мөрнийхөө рашаанаас  
 Ганц ч болов амсах сан гэж  
 Амьтан хүмүүс хөөрөлдөхийг  
 Сонссон би  
 Ангасан цангасан амьтныг аварч өршөөсөн  
 Алдсан оносон хүнийг булхуулж ариусгасан  
 Ариун бумбанд хийгээд авахад хичнээн удсан ч муудаагүй  
 Аврал эрээд очвол амь насыг минь даасан  
 Рашаан их мөрөн  
 Ариун Ганга минь  
 Мөргөлчин хүний итгэлийн зул  
 Мөрөөдсөн хүний сэтгэлийн дуудлага  
 Гэгээн хөх ертөнцөд ахин дахин заяахгүй  
 Ганган цэнхэр Ганга мөрөн  
 Ганцхан

2007 оны I сар

### Тайлбар

- I. Эртний домогт 4 зугийг сахигч 4 бурхад байдгийн Дорно зугийг сахигч бурхны нэрийг “Дридраашидраа” гэдэг.
- II. Домогт гардаг Тэнгэр язгуурт “Гришинаа” бурхны нэр
- III. Индраа – Хурмаст тэнгэр
- IV. Брахма гэж Ганга мөрөн эх авдаг нуурын нэр
- V. “Будлан” Ганга мөрний эх авдаг уулсын нэр
- VI. Галбирваасан нэгэн зүйл модны нэр